

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРТ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХАВСРАЛТЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр 50.0 сая еврогийн “Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийг байгуулсан. Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 25 дугаар тогтоол, 2024 оны 94 дүгээр тогтоол, 2025 оны 113 дугаар тогтоолын дагуу 5 төслийг хэрэгжүүлэхээр тогтсон бөгөөд өнөөдрийн байдлаар 3 төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан байна. Харин “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл” 84.5 хувь, “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл” 90 хувийн хэрэгжилттэй байна.

Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд тус хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш санхүүжилтийг 5 жилийн дотор олгож дуусахаар заасан. Тус төслийн түлхүүр гардуулах гэрээ 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд санхүүжих эцсийн хугацаа 2025 оны 02 дугаар сарын 20-оор дуусгавар болсон тул төслийн үлдэгдэл 0.9 сая еврог санхүүжүүлэхийн тулд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан хугацааг өөрчлөх шаардлага үүссэн байна.

Иймд “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд баригдах Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн худалдан авах ажиллагааг зарлаж, гэрээ байгуулахад нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-т нэмэлт, өөрчлөлт оруулж гэрээг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах, тус байгууламж болон Орхон аймгийн хатуу хог боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл удааширч байгаатай холбогдуулан, барилга байгууламжийг дуусгаж, эцсийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8-р зүйлд заасан санхүүжилтийн эцсийн хугацааг 3 жилээр сунгах, мөн Засгийн газрын тогтоолоор шинэчлэн хуваарилсан “Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн 50.0 сая еврогийн хуваарилалтыг баталгаажуулах нэмэлт, өөрчлөлтийн хавсралтын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц 5000м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 10000м3 болгож өсгөснөөр өнөөдрийн үнийн дүн нэмэгдэж байгаа эсэх, улсын төсвөөр цэвэршүүлэх байгууламжийг үүнтэй адил багтаамжтайгаар барьсан тохиолдолд төсөвт өртгийн үнийн зөрүү хэд байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн санхүүжих дүн нэмэгдээгүй, зөвхөн хугацааг сунгаж байгааг тодруулж, төслүүдийн хэрэгжилтийн явцыг бодитой дүгнэсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа саарал усны хэрэглээг хөхүүлэн дэмжих тал дээр тарифын болон тарифын бус урамшууллын механизм бий болгох талаар хариуцсан салбарын байгууллага ямар бодлого баримталж байгаа талаар, Сангийн яамнаас саарал усны хэрэглээг дэмжиж эсвэл, эрчим хүчний хэрэглээг нь багасгаснаар гарах зардал нь буурах төлөвлөлтийг цаашид хийх эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшилцөх эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ**



Л.СОРОНЗОНБОЛД